

**"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**
(жилийн эцсийн байдлаар)

2026 оны 01 дүгээр сарын 02

д/д	Арга хэмжээ, зорилт	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
Зорилт 1. Монгол улсын хөгжлийн бодлогод туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ.							
1.1	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх.		Гүйцэтгэлийн хувь	Барилгын ажлын гүйцэтгэл-0%	<p>I улирал: Санхүүжилтийн гэрээ болон барилга угсралтын гэрээг байгуулсан байна.</p> <p>II улирал: Барилгын ажил эхлэхтэй холбоотойгоор холбогдох зөвшөөрөл, газар чөлөөлөлт, кемпийн бэлтгэл ажил бүрэн хангагдан барилгын ажил эхлүүдсэн байна.</p> <p>III улирал: Барилгын ажлын гүйцэтгэл 5 хувьд хүрсэн байна.</p> <p>IV улирал: Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.</p>	<p>"Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхээр "Тавантолгой төмөр зам" ХХК болон БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК нарын хооронд хийсэн гэрээг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан. 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн 3 талт гэрээг "Эрдэнэс таван толгой" ХК, "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК, "Тавантолгой төмөр зам" ХХК нар байгуулсан.</p> <p>Барилгын ажлын бэлтгэл ажлын хүрээнд холбогдох зөвшөөрөл газар чөлөөлөлт, кемпийн бэлтгэл ажил бүрэн хангагдаж барилга угсралтын ажил хийгдэж байна.</p> <p>Төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК-ий 437 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлж хамтран ажиллаж байна.</p> <p>Уг төслийг хэрэгжүүлэхэд хаалттай бүсийн журам батлагдаагүй улмаас барилгын ажлын явц удааширч 90 хоногийн алдагдал хүлээнэвч үүдэн 2025 оны жилийн эцсийн байдлаар Барилга угсралтын гүйцэтгэл 5%-тай үргэлжилж байна.</p>	50%

1.2	Компанийн хэрэгжүүлж байгаа төслүүдийг бүрэн дуусгаж гэрээг дүгнэх.		Баталгаажуулсан актын тоо	Төслүүдийн ажил хүлээлцэх акт, явц дундын төлбөрийн хүсэлтүүд батлагдсан.	<p>I улирал Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв төслийн гэрээг дүгнэж хаасан байна. Зүгшрүүлэлтийн тээврийг эхлүүлсэн байна.</p> <p>II улирал: Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын цогцолбор төсөл, Тавантолгой-Зүүнбаян холболтын төмөр замын төсөл, Шилжүүлэн ачих Терминал төслийн гэрээг дүгнэсэн актыг дүгнэж хаасан байна.</p>	<p>2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс зүгшрүүлэлтийг эхлүүлсэн - "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн багийн ахлагчийн 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/289 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд доголдлыг арилгаж тоног төхөөрөмжийн сайжруулалт хийх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг 4 удаа хүргүүлсэн. "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Бодь интернэшнл" ХХК нарын хооронд байгуулсан Гэрээг дүгнэх акт болон санхүүжүүлэлтийн гэрээ дүгнэх актыг баталгаажуулах ажил 95% хувьтай явж байна. Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/311 дүгээр "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаал гарсан. Уг тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудын холболтын төмөр зам, Тавантолгойн күүрс ачих логиستيкийн төв, Богдхан төмөр зам зэрэг төслүүдийн хүрээнд бий болсон тоног төхөөрөмж, барилга байгууламж, эд хөрөнгийг төрийн өмчид бүртгүүлэх, төслүүдийн гэрээг дүгнэх асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг, удирдамжийг баталсан. Ажлын хэсгийн гишүүдэд холбогдох материалыг хүргүүлсэн.</p>	90%
1.3	Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах.		ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан эсэх	"Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн 8.2.2 -т заасан уул уурхай, экспортын чиглэлийн авто	<p>I улирал: Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна.</p>	<p>"Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хэлэлцүүлэх тухай" албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 01/379 дүгээр албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн</p>	

				зам болон төмөр замыг хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт "Шивээхүрэн-Тавантолгой" чиглэлд төмөр зам барих талаар тусгагдсан. 2024.10.04-ний өдрийн А/160 ажлын хэсэг байгуулагдсан, ТЭЗУС боловсруулагд аж байна.		яамнаас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08/1150 тоот албан бичгээр Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг дахин сайжруулах тухай бичиг ирүүлсний дагуу Зам, тээврийн яаманд 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 04/1412 тоот албан бичгээр хүргүүлсэн.	30%
1.4	Хөдлөх бүрэлдэхүүн угсрах технологийн төв ТЭЗУ боловсруулах.	327,356,000.0 /ТЭЗУ боловсруулахад шаардлагатай төсвийн зардал/	ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан эсэх	2024.09.05-ны өдрийн А/138 дугаартай Төмөр замын Хөдлөх бүрэлдэхүүн угсралтын технологийн төвийн ТЭЗУС боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. ТЭЗУС-ын гүйцэтгэл 60%-тай.	I-И улирал: Хөдлөх бүрэлдэхүүн угсралтын технологийн төвийн ТЭЗУС-ийг Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна.	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Зам, Тээврийн яамны дэргэдэх Төмөр зам, далайн тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн боловсруулсан "Ачааны вагон угсрах үйлдвэр"-ийн ТЭЗУС-г хэлэлцэж, 100%-ийн саналаар ТЭЗУ болгохыг дэмжсэн.	100%
1.5	"Богдхан төмөр зам" төслийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад төслийн хүрээний баримт	2,196,984,412.68	Ажлын явц	Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээг дүгнэхтэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээний	I-II улирал: Холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай	Илүү санхүүжилт олгосон 4 байгууллагыг төлбөрөө барагдуулах талаар удаа дараа албан бичгийг хүргүүлсэн боловч авлагаа барагдуулаагүй тул хуулийн байгууллагад шилжүүлэхээр холбогдох баримтыг цуглуулан ажиллаж байна. Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/311 дүгээр "Ажлын	30%

	материалуудыг хүлээлгэн өгөх.			гүйцэтгэл 30%-тай байна.	баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж гүйцэтгэл 100%-д хүрсэн байна. Маргаан гарсан тохиолдолд холбогдох байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлсэн байна.	хэсэг байгуулах тухай” тушаал гарсан. Уг тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудын холболтын төмөр зам, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв, Богдхан төмөр зам зэрэг төслүүдийн хүрээнд бий болсон тоног төхөөрөмж, барилга байгууламж, эд хөрөнгийг төрийн өмчид бүртгүүлэх, төслүүдийн гэрээг дүгнэх асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг, удирдамжийг баталсан. Ажлын хэсгийн гишүүдэд холбогдох материалыг хүргүүлсэн.	
--	-------------------------------	--	--	--------------------------	---	---	--

Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.

2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг ханган ажиллах.		Ажлын явц	ХАБЭА-н тухай Монгол улсын хууль, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын тушаал болон бусад тушаал шийдвэрийг мөрдөж ажилласан.	<p>I улирал: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.</p> <p>I-IV улирал: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандартын шаардлагад нийцсэн аюулгүй ажлын байр, ажиллах орчныг бүрдүүлж ажилласан байна.</p>	<p>Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хэлтсийн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандартын шаардлагад нийцсэн аюулгүй ажлын байр, ажиллах орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Гамшгийн эрсдэлийн үнэлгээг "УСТ БЭЛЧИР" ХХК-тай гэрээ хийн Тавантолгой, гашуунсухайт өртөө болон нийт барилга байгууламжид аюулын 5 төрлөөр хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний явцад нийт ажилчдад Галын аюулгүй байдал, түүнд холбогдох хууль дүрмийн хүрээнд онолын сургалт, мөн гамшгийн эрсдэлийн сургалтыг тус тус зохион байгуулж 178 ажилтныг хамруулсан.</p> <p>Тайлант хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг, хяналтыг 36 удаа зохион байгуулж, нийт 134 үл тохирлыг илрүүлэн холбогдох зэсвар, сайжруулалтын арга хэмжээг шуурхай</p>	100%
-----	---	--	-----------	---	---	--	------

					<p>авч хэрэгжүүлэв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох стандарт, дотоод журам болон Гүйцэтгэх захирлын баталсан туцаалын хэрэгжилтийг хангах зорилгоср 34 удаагийн дотоод сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1,195 ажилтныг хамруулав. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт 3 төрлөөр өгч, тайлант хугацаанд давхардсан тоогоор 3,348 ажилтанд хүргэн ажилласан. Өдөр тутмын зааварчилгааг инженер-техникийн ажилтанд тогтмол өгч, тухайн өдрийн аюултай бүс, анхаарах шаардлагатай нөхцөл, багаж, тоног төхөөрөмжийн үзлэг, хувийн хамгаалах хэрэгслийн (PPE) бүрэн хэрэглээ, гал, цахилгаан болон өндөрт ажиллах үеийн эрсдэлийн анхааруулга, ажилчдын санал, анхааруулгыг системтэйгээр бүртгэн баталгаажуулж байна. Түүнчлэн MNS 4969:2000 стандартын дагуу барилгын талбай, технологийн зам, гүүрийн суурийн ажил болон бетон зуурмагийн үйлдвэрийн тусгай зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлж байна.</p>		
2.2	<p>Ажилтны эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээ, журмын хэрэгжилтийг хангах, Эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх.</p>		Ажлын гүйцэтгэл	<p>"УБТЗ" ХНН-ийн харьяа нэгдсэн эмнэлэгт 2024 онд ХАГ2024/08 дугаартай гэрээний дагуу 300 ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.</p>	<p>I-II улирал: Эрсдэл өндөртэй 5 ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж, ажиллах үеийн эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.</p> <p>I-IV улирал: Шинээр ажилд орж буй ажилтныг Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан эсэхэд</p>	<p>Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг "ДАБЛЮ ЭЙЧ ЭЙ" ХХК-тай АГГ-2024/77 дугаартай гэрээ хийж, 31 ажлын байранд шөнийн болон өдрийн ээлжинд ажиллаж байгаа 206 ажилтныг хамруулан хувийн хэмжилтийн багаж зүүлгэн талбайн орчны хэмжилтийг хийсэн. Хэмжилтээр агаарын температур, чийгшил, шуугиан, угаарын хий, гагнуурын утаа, бүх биеийн доргио, гэрэлтүүлэг гар шууны доргион, агаарын урсгалын хурд, нүүрстөрөгчийн дутуу исэл хэмжин ажилласан. Тайлант хугацаанд шинээр ажилд орсон 13 ажилтан урьдчилсан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулсан ба хугацаат</p>	100%

				<p>хяналт тавин ажилласан байна. Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан эсэхэд хяналт тавин ажилласан байна.</p> <p>IV улирал: Галт тэрэгний хөдөлгөөний болон сэлгээний ажилд шууд холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг 300 ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулахад хяналт тавин ажилласан байна.</p>	<p>эрүүл мэндийн үзлэгийг улсын төв 2 дугаар эмнэлэгтэй хамран зохион байгуулж 356 ажилтныг хамруулсан.</p> <p>Ядаргаа, эргономик, химийн болон гэрэлтүүлгийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тандах асуумжаар асууж эрсдэлийн үнэлгээг хийсэн. Үнэлгээгээр:</p> <p>Давхардсан тоогоор өндөр эрсдэл 20, дунд эрсдэл 15, бага эрсдэл 2 тодорхойлогдсон. Эрсдэлийн үнэлгээний дагуу хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, 11 аюулыг мэдээлэх хуудас ирж түүний мөрөөр залруулах арга хэмжээ авч ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажилласан. Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг бүрдүүлэн хангах зорилгоор "Эмийн сангийн буланг" байгуулж, хэрэгцээт эм, хэрэгслүүдийг захиалан нөөцөлж ажиллав.</p>
--	--	--	--	---	--

Зорилт 3. Байгаль орчны багц хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангана.

3.1	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд модны тарьц суулгац тарих.	Батлагдсан төсвийн дагуу 50.0	Тарьсан модны тоо	<p>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд 10000 ширхгээс доошгүй мод тарьсан байна.</p>	<p>I улирал: ААН-ийг сонгож гэрээ байгуулсан байна.</p> <p>II улирал: 5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.</p> <p>III улирал: 5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.</p> <p>2025 онд нийт 10000 ш-ээс доошгүй мод суулгацыг ТТГС чиглэлийн төмөр замын дагууд тариалсан байна.</p>	<p>Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд I, II улиралд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон.</p> <p>Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн ТГ/484 тоот албан бичгийг ирүүлсэн. Гүйцэтгэх захирлын А/56 тоот тушаалын дагуу "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд Өвөрхангай аймгийн Хэрхорум хотын орчимд шинээр таригдсан ойн сан бүхий газарт 5000 суулгац тариалсан.</p>	50%
-----	---	-------------------------------	-------------------	---	---	---	-----

Зорилт 4. Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.

4.1	Компанийн хөрөнгө оруулалт, эдийн засгийг үр ашигтай төлөвлөх.		Тайлан гаргаж, удирдлагад танилцуулсан эсэх	2025 онд мөрдөж ажиллах эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний дагуу	I-IV улирал: Батлагдсан төлөвлөгөөний дагуу Компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, тээврийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэлийн тайланг гарган, тайлбарын хамт удирдлагад танилцуулсан байна.	<p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг түрээслүүлж, 507 орон тоог "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлсэн.</p> <p>Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр А/106 тоот тушаалаар 108 ажилтны орон тооны зохион байгуулалтаар батлагдсан.</p> <p>"Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хүрээнд компанийн шинэ бүтэцтэй холбоотойгоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшингийн тодотголыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, тээврийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэлийн тайланг улирал бүр гарган, тайлбарын хамт удирдлагад танилцуулсан.</p> <p>Компанийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд менежмент хийж, үйл ажиллагаанд шууд зарцуулагдахгүй хэсгийг хугацаатай хадгаламж үүсгэх замаар хүүгийн орлогыг төвлөрүүлэн</p>	100%
-----	--	--	---	---	--	--	------

					ажилласан. Үүний үр дүнд хүлээгдэж буй гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгө эргэлтэд орж, нийт 4,377.1 сая төгрөгийн хүүгийн орлого олсон.	
4.2	Төрийн хэмнэлтийн хууль болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/333 дугаартай албан бичгээр өгөгдсөн үүргийг тус тус хэрэгжүүлэх хүрээнд "Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах төлөвлөгөөг"-г боловсруулан, батлуулж биелэлтийг хангаж ажиллах.	Төлөвлөгөө батлуулж, тайлагнасан эсэх	2024 оны III улирлын ХБГ-ээр орлого нэмэгдүүлэх төлөвлөгөөний биелэлт 37-иар давуулан биелүүлсэн ба зардал бууруулах төлөвлөгөө 4 дахин давж тус тус үр дүнтэй биелсэн.	I улирал: Орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх удирдлагаар батлуулсан байна. II-IV улирал: Төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргаж, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр улирал бүр хангасан байна.	Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах ажлын төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/12 тоот тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд бүтэц орон тэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор уг чиг үүргийн хүрээнд ажиллаж байсан зарим нэгж, албан тушаалын хэрэгцээ шаардлагагүй болж, орон тооны хэмнэлт хийгдсэн 2025 оны III дугаар улирлын гүйцэтгэлээр зардал бууруулах ажлын төлөвлөгөөг 12,021.7 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Гүйцэтгэх захирлын А/107 тоот тушаалыг 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр "Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах" төлөвлөгөөг баталж, тушаалын хэрэгжилтийг гүйцэтгэх удирдлагад улирал бүр мэдээллээр ханган ажилласан.	100%
4.3	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн санхүүжилтийн мэдээг гаргах.	Ажлын явц	УИХ-ын 2023 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоол тус тус батлагдсан.	III-IV улирал: Санхүүжилтийн гэрээ ба Барилга угсралтын ажлын гэрээнд заасан захиалагчийн хяналтын санхүүжилттэй холбоотой тайланг төслийн явцтай нийцүүлэн боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангасан байна.	Гашуунсухайт-Ганцмод боомт хил дамнасан төмөр замын төслийн гүйцэтгэчийн тендерт шалгарсан төсөвт өртөг 848.9 тэрбум төгрөг бөгөөд санхүүжилтийн гэрээ, барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдсан. 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөр болох 240,497,673,190.6 төгрөгийг гүйцэтгэгч талд шилжүүлсэн. Санхүүжилтийн гэрээ ба Барилга угсралтын ажлын гэрээнд заасан захиалагчийн хяналтын санхүүжилттэй холбоотой тайланг төслийн явцтай	100%

					нийцүүлэн боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.		
4.4	Компанийн хэрэгжүүлж байгаа теслүүдийн гүйцэтгэлийн мэдээг гаргах.		Ажлын явц	<p>2024 оны байдлаар:</p> <p>- "ТНАЛТ" төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын орлогын гүйцэтгэл 97 хувьтай.</p> <p>- "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян"-ын төмөр замуудыг холбох төмөр замын төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын санхүүжилтийн гүйцэтгэл 78 хувьтай.</p> <p>- "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын санхүүжилтийн гүйцэтгэл 82 хувьтай байна.</p>	<p>I-IV улирал: Төсөл дууссантай холбоотойгоор захиалагчийн хяналтын санхүүжилтийн тайланг гарган, гэрээний дүнг шалгаж, үр дүнгийн талаарх мэдээллийг удирдлагад танилцуулсан байна.</p>	<p>"ТНАЛТ" төслийн санхүүжилт 313,192 сая төгрөг байхаас 99 хувь буюу 309,639 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. IPC 11 хянагдах шатандаа явж байна.</p> <p>"Тавантолгой-Гашуунсухайт", болон "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын төслийн комиссын дүгнэлт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гарч, дүгнэлтийг үндэслэн төслийн IPC-009, 010-ийг баталгаажуулж, "Бодь интернэшнл" ХХК-д хүргүүлсэн ба бүтээн байгуулалтын явц нь 97 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 189.1 тэрбум байна.</p> <p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн явц дундын төлбөр баталгаажуулалт 2025 онд хийгдээгүй, мөн нүүрс урьдчилан борлуулах гэрээний дагуу санхүүжилт хийгдээгүй тул явцын мэдээнд өөрчлөлт ороогүй болно.</p> <p>Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/311 дүгээр "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаал гарсан. Уг тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Зүүнбаян болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудын холболтын төмөр зам, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв, Богдхан төмөр зам зэрэг төслүүдийн хүрээнд бий болсон тоног төхөөрөмж, барилга байгууламж, эд хөрөнгийг төрийн өмчид бүртгүүлэх, төслүүдийн гэрээг дүгнэх асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг, удирдамжийг баталсан.</p> <p>Тушаалын хэрэгжилтийн хүрээнд санхүүжилтийн тайланг гарган, гэрээний</p>	90%

4.5	Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах.		Батлуулсан эсэх	Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулсан.	IV улирал: Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан байна.	дунг үр дүнгийн талаарх мэдээллийг гарган ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/150 тоот тушаалын дагуу 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөгөөний саналыг боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх тухай дотоод албан бичгийг бүх газарт хүргүүлсэн. Төслийн удирдлагын газар болон Захиргаа, эрх зүйн газартай 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр 2026 оны ЭЗҮҮЗТ-г хэлэлцүүлэн, газруудаас гаргасан саналын дагуу төлөвлөгөөг дахин боловсруулж, 2025 оны 12 сарын 26-ны ТУЗ-ийн зөвлөлийн 17 дугаар тогтоолоор баталсан.	100%
4.6	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын байгууллагын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх.		Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Аудитын удаагийн зөвлөмжийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. 2	II улирал: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан байна. II-III улирал: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Үндэсний Аудитын газраас 2024 оны санхүүгийн аудитын тайлангаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 15-нд Гүйцэтгэх захирлаар батлуулсан. 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланд төлбөрийн актын-1, албан шаардлага-10, зөвлөмж-8 өгсөн. Үүнээс актын биелэлт-100%, албан шаардлага-66.7%, зөвлөмжийн биелэлт-94.3%-ийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн аудитын биелэлтийг https://shilendans.gov.mn/organization/55698?ry=2024&group=5&rfor=148255&rf=1837&rm=7 болон https://fas.audit.mn/?code=a9385e2ce94ed021242a25915c69583d#/web/Home/act_plan аудитын программд шивж оруулсан.	90%
4.7	Компанийн батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэлээр зардлын санхүүжилтийг олгож хяналт тавьж.		Тайланг хугацаанд нь	2024 оны хагас жилийн тайланг 7 дугаар сарын 20-ны дотор	I улирал: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар	2024 оны санхүүгийн жилд 127,5 тэрбум төгрөгийн орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 67,1 тэрбум,	100%

	<p>нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргаж, тайлагнах.</p>	<p>хүргүүлсэн эсэх</p>	<p>гаргаж, тайлагнасан.</p>	<p>сарын 10-ны өдрийн дотор. III улирал: Хагас жилийн санхүүгийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 20-ны дотор тус тус гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.</p>	<p>ерөнхий удирдлагын зардал 10,3 тэрбум төгрөг, үйл ажиллагааны бус зардал 15,3 төгрөгийн тус тус зардалтай 39,9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, холбогдох тайланг www.etailan.mn, www.ebalance.mn, www.etax.mn цахим системд хугацаанд нь тайлагнаж ажилласан.</p> <p>Компанийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн дүнгээр 1,930,114.72 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 2,617,067.87 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө нийт 4,547,182.59 сая төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2025 оны хагас жилийн байдлаар нийт хөрөнгө 0.05 хувиар буурч 4,544,703.88 сая төгрөг байна. Компанийн хэрэгжүүлж буй төслүүдийн IPC баталгаажуулан үндсэн хөрөнгийг орлогод бүртгэсэнтэй холбоотойгоор 2025 оны эхний хагас жилийн байдлаар -88.74% хувиар буурч, 174,756.02 сая төгрөг болсон. Урьдчилж төлсөн тооцоо буурсан шалтгаан нь Тавантолгой-Гашуунсухайт төслийн хөрөнгийн баланс бүртгэсэн нь нөлөөлж байна. Компанийн 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох дээд шатны байгууллагуудад тайланг www.etailan.mn, www.ebalance.mn, www.etax.mn цахим системд хүргүүлсэн.</p>
<p>Зорилт 5. Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.</p>					
<p>5.1</p>	<p>Хууль тогтоомж, Засгийн газар, төрийн бусад эрх бүхий дээд байгууллагын шийдвэр, удирдамж, чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжилтийг хангуулах.</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ЗТЯ-нд 10 удаа хүргүүлсэн.</p>	<p>I-IV улирал: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулж, дээд шатны байгууллагад хэрэгжилтийг хүргүүлэн ажилласан байна.</p>	<p>Компанийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөлтэй холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг Компанийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан зохион байгуулж, улирал тутам хэрэгжилтийг компанийн Хяналт.</p> <p>100%</p>

					шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын албанд, хагас, бүтэн жилийн хэрэгжилтийг Зам, тээврийн яамны салбарын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэн ажиллаж байна. Дээд газрын тогтоол, шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг улирал бүр заасан хугацаанд Зам тээврийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.		
5.2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаалыг хэрэгжүүлж, тайлагнах, мэдээллээр хангах.	-	Ажлын гүйцэтгэлээр	Шийдвэрт нийцсэн эдийн засгийн тооцоо, санхүүгийн бүртгэл хийсэн.	I-IV улирал: Хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг тухай бүр хангуулан ажилласан байна. I-IV улирал: Гүйцэтгэх захирлын тушаалыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнан ажилласан байна.	Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал 3 удаа хуралдаж, 9 асуудал хэлэлцэж, 7 тогтоол 2 хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 9 удаа хуралдаж, 20 асуудал хэлэлцэж, 16 тогтоол 7 тэмдэглэл гаргасан, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо 2 удаа хуралдаж 2 дүгнэлт, Аудитын хороо 4 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэж, 4 дүгнэлт тус тус гаргасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажилласан. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд А тушаал 145, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 1005 баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
5.3	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах.	-	Хэрэгжилтийн хувь	2024 онд Бодлогын бичиг баримт бичгүүдийг бүх ажилтнуудад таниулан ажилласан.	I-IV улирал: Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай хүний нөөцөөр хангах	2025 оны жилийн эхний байдлаар компанийн нийт 781 ажилтнаас 625 буюу 80 хувь нь төмөр замын чиглэлийн инженер, техникийн ажилтнууд байсан нь төмөр замын тээвэрлэлтийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөцийн үндсэн бүрэлдэхүүнийг бүрдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны хоёрдугаар улирлын эцэст төмөр замын суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсээр шилжүүлсэнтэй холбогдуулан суурь бүтэц, тээвэрлэлтийн	100%

					<p>үйл ажиллагаанд шууд хамаарах 443 ажлын байр, дэмжих чиглэлийн 64 ажлын байрыг хамтад нь шилжүүлсэн. Ингэснээр төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай хүний нөөцийн хангалт, залгамж чанарыг бүрэн хангаж ажилласан.</p> <p>Шилжилтийн дараагаар компанид үлдсэн хүний нөөцийг чиг үүргийн оновчтой хуваарилалт, ажлын зохион байгуулалтыг сайжруулах замаар үр ашигтайгаар ашиглаж, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаатай уялдсан дэмжих болон удирдлагын чиг үүргүүдийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	
Б.4	Компанийн гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.	Тоо хэмжээ	<p>2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 28 төрлийн дотоод сургалтад 461, 3 төрлийн гадаад сургалтад 16 ажилтныг тус тус хамруулсан.</p>	<p>I-IV улирал: Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу гадаад, дотоодын сургалтад тогтмол хамруулсан байна.</p>	<p>Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний хүрээнд Суурь бүтцийн газрын Дохимол холбоо, эрчим хүчний хэлтсийн 2 ажилтныг ШУТИС-ийн Эрчим хүчний инженерчлэлийн сургуулиас зохион байгуулсан "Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх" сургалтад хамруулсан. Төлөвлөгөөт бус сургалтаар нийт 82 ажилтныг Эйбл Софт программын сургалтад хамруулсан. Шинэ ажилтны чиглүүлэх сургалтад 12 ажилтныг хамруулан тус тус ажилласан. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу төсөвт сургалтын үйл ажиллагааг зогсоосон. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит хурлаар компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/120 дугаар тушаалаар сургалтын төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан.</p>	90%

					Худалдан авах ажиллагааны АЗ сургалтанд 10, Хүний нөөцийн мэргэжлийн чиг хандлагын талаар мэдээ, мэдээлэл авах, шилдэг туршлагыг судлах сургалтанд 6, Хөрөнгийн үнэлгээний сургалт (эрх авах)-нд 2, Нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн сургалтанд 3, Excel програмын олон улсын стандарт техникийг эзэмших, бизнесийн логикийг нүдэнд харагдахуйц болгох, тодорхой жишээн дээр практик дадлага хийх сургалтанд 3, Төслийн удирдлагын багц сургалтанд 20, Таван төслийн хүрээнд архивын баримтад нягтлан шалгалт хийх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх, төрийн архивт баримт шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх, албан хэргийн хөтлөлтийн сургалтанд 55, Дотоод аудиторыг мэргэшүүлэх сургалт 1 ажилтан тус тус хамрагдсан. Нийт давхардсан тоогоор 182 ажилтан сургалтанд хамрагдсан байна.		
5.5	Авлигын эсрэг төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллах.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	41 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдээллийг гаргуулан баталгаажуулсан.	<p>I улирал: Компанийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах.</p> <p>II улирал: Удирдах болон эрх бүхий албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд шинэчлэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хуулийн хугацаанд хянуулсан байна.</p> <p>III улирал: Авлигын нийгмийн хор</p>	<p>2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Гүйцэтгэх захирлаар батлуулсан. Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 22 этгээдийн ХАСУМ-ийг хянуулж, 27 албан тушаалтны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж, шинээр томилогдсон 13 албан тушаалтны ХАСХОМ-ийг гаргуулан баталгаажуулсан. АТГ-аас зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл, бүрдүүлэлт хариуцсан ажилтанд зориулсан онлайн сургалтад 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ЭБАТ хариуцсан ажилтан оролцсон.</p>	70%

				<p>аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тээчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор компанийн эрх бүхий ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг АТГ-тай хамтран зохион байгуулах.</p> <p>IV улирал: АТГ-ын зохион байгуулах Авлигын эсрэг үе шаттай сургалтад эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан байна.</p>		
5.6	Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.		Хэрэгжилтийн хувь	<p>2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 55 мэдээ, 30 видео контент, 14 инфографик, 30 постор нийт 129 мэдээ, мэдээлэл бэлтгэн давтагдсан тоогоор 24 телевиз, 42 сайт, өдөр тутмын сонин, www.ftz.mn веб сайт, байгууллагын фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан. Олон нийтэд компанийн үйл</p> <p>I-IV улирал: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухай бүр хангаж ажиллана.</p>	<p>" Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай", "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд, Shilen.gov.mn сайтад тухай бүр шаардлагатай мэдээллийг байршуулан ажилласан. Байгууллагын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж, шинэчлэл хийх зөвлөмж ирүүлсний дагуу байгууллагын веб сайтад "НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ" цэсийг шинээр үүсгэж 121 мэдээ мэдээллийг шинэчлэн байршуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын шав тавих ёслол 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр болох үеэр хэвлэл мэдээллийн 33 байгууллагын / телевиз, сайт, сонин/ сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулж тайлан авсан бөгөөд 10 гаруй телевиз, сайт лайваар шууд дамжуулалт хийж 100 гаруй мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн.</p>	70%

				ажиллагааг сурталчилж, 540 мэдээ мэдээллийг оруулан ажилласан. Хуулийн хүрээнд нийт 117 мэдэгдлийг хүргүүлсэн.		Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын анхны тулгуур шонгийн цэгийн ёслолын ажиллагаа 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлэх үеэр МҮОНТ-ийн багийг ажиллуулж, 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулж мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Компанийн албан ёсны веб сайтад (www.tz.mn) 2025 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар компанийн албан ёсны веб сайтад (www.tz.mn) мэдээ 91, видео контент 43, постер 50, инфографик, тендер зар, ажлын байрны зар зэрэг нийт 203 гаруй контент нийтлэгдсэн байна	
5.7	Батлагдсан төсвийн хүрээнд компанийн худалдан авах ажиллагааг төлөөлөх, зохион байгуулах, тайлагнах.		Хэрэгжилтийн хувь	2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 200 төсөл арга хэмжээг 19 тэрбум төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.	I улирал: Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулах. II-IV улирал: Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	Компанийн 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г батлуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтаар 52 төсөл арга хэмжээг 36.5 тэрбум төгрөг, урсгал зардлаар 257 төсөл арга хэмжээг 51.8 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн, Компанийн төсвийн тодотгол 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар тогтоолоор батлагдсаны дагуу худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 127 төсөл арга хэмжээг 10.5 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлуулсан. Үүнээс хөрөнгө оруулалтаар 8 төсөл арга хэмжээг 413 сая төгрөгөөр, Техник технологийн хяналт хэрэгжүүлэхээр 14 төсөл арга хэмжээг 7.5 тэрбум төгрөгөөр, урсгал зардлаар 105 төсөл арга хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн. Нээлттэй болон харьцуулалтын аргаар 23 тендер шалгаруулалт төлөвлөсөнөөс 15 тендерийн урилгыг олон нийтэд цахимаар зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	30%

5.8	Компанийн ажилтнуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол хүнсээр үйлчлэх, амрах байраар хангах.	Тоо хэмжээ	2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар давхардсан тоогоор 79,750 инженер техникийн ажилтан Тавантолгой өртөөнд 115,717, Гашуунсухайт өртөөнд 45,849 хоолны захиалга тус тус хийгдэж хоол хүнсээр үйлчилсэн байна.	<p>I улирал: Ажилтнуудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол үндээр үйлчилж, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>IV улирал: Төмөр замын аюултай бүсийн дэглэм, хөдөлмөрийн дотоод журмыг хангуулах, сахилга дэг журам сахиулах, төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.</p>	<p>2025 оны 1-5 дугаар сард давхардсан тоогоор 24,500 инженер техникийн ажилчдад Тавантолгой өртөөнд 52800, Гашуунсухайт өртөөнд 18815 өглөө, өдөр, орой, шөнө хоолны захиалга тус тус хийгдэж, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцлөөр хангаж ажилласан. Монгол улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "Титан хас фүүд" ХХК-тай хийсэн ажилчдын хоол катерингийн үйлчилгээ үзүүлэх гэрээг дуусгавар болгосон. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн талбайд ажиллаж буй инженер техникийн ажилтнуудын хоолны захиалгыг "Монголын төмөр зам" ТӨХК-д өгч, давхардсан тоогоор 993 ажилтанд катеринг үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Харуул хамгаалалтын хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө 2025 оны 01 сард батлагдсан. Уг төлөвлөгөөнд төмөр замын аюулгүй бүсийн дэглэм, төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшний аюулгүй байдлыг хангах асуудлуудыг тусгасан байсан. Монгол Улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийн дагуу суурь бүтэц болон тээвэрлэлтийн чиг үүрэг "Монголын төмөр зам" ТӨХК рүү шилжэхэд харуул хамгаалалтын хэлтэс үүрэг чиглэлийн дагуу мөн шилжсэн. "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих" төслийн хэрэгжилтийн хүрээнд Гашуунсухайт дахь төслийн талбай болон оффист гэрээт харуул хамгаалалтын ажилтнуудыг</p>	100%
-----	---	------------	---	---	---	------


					<p>хөлсөөр ажиллуулан, төслийн бүсийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Гэрээт харуул хамгаалалтын ажилтнууд нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, сахилга дэг журмыг мөрдүүлэх, төслийн талбайн аюулгүй ажиллагааг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд 24 цагийн тасралтгүй ажиллагаатай, ээлжийн зохион байгуулалтаар ажиллаж, төслийн талбайн аюулгүй, хэвийн үйл ажиллагааг тогтвортой ханган ажилласан.</p> <p>Мөн төслийн талбайн өдөр тутмын үйл ажиллагааны нөхцөл байдал, аюулгүй байдлын хяналт шалгалтын үр дүн, үүссэн болон урьдчилан сэргийлсэн нөхцөл байдлын талаарх рапорт, мэдээллийг тогтмол нэгтгэн холбогдох нэгжид хүргүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлсэн байна.</p>	
5.9	Компанийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх.		Ажлын явц	<p>- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд: Санамж бичиг-1 Албан уулзалт-10 Албан томилолт-4 Гадаад хэл дээрх аман орчуулга-10 Гадаад хэл дээрх бичгэн орчуулга-80 хуудас</p> <p>- Дотоод хамтын ажиллагааны хүрээнд:</p> <p>I улирал: 2025 онд хийгдэх гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулна</p> <p>II улирал: Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнчлэлээр элсэх ажлыг зохион байгуулж, элссэн байна</p> <p>III-IV улирал: Компанийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд техник</p>	<p>"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 4 чиглэлийн хүрээнд 20 ажил, арга хэмжээтэйгээр төслийг боловсруулан Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлсэн, компанийн бүтэц, орон тоо шинэчлэгдэхтэй холбоотойгоор хойшлуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар тогтоолоор бүтэц, орон тоо өөрчлөгдөж, 108 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Шинэчлэгдсэн бүтэцтэй уялдуулан</p>	50%

				<p>Нийгмийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЕБС-ийн II сургуулийн багш, ажилчидад компанийн хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажлыг танилцуулсан.</p>	<p>технологи, сургалт, туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.</p> <p>- Дотоод хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн байгууллага, удирдлагуудтай хамтран ажиллаж хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.</p> <p>- Ажилчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хамт олны дотоод уур амьсгал, эв нэгдэл, хандлагыг эерэг болгож байгууллагын соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдсэн байна.</p>	<p>гадаад, дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах чиглэлээр 2025 оны төсвийн тодотголд санал хүргүүлсэн.</p> <p>Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар спортын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батласан.</p> <p>Авто тээвэр, нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Зам, тээврийн яамны харьяа байгууллагуудын дундах туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан.</p>	
Зорилт 6. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.							
6.1	Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.		Хэрэгжилтийн хувь	<p>Компанийн үндсэн үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, төсөв, санхүүгийн байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийж үр дүн үр дагаврыг үнэлэн, үйл ажиллагааг</p>	<p>I-IV улирал: Хууль, тогтоомжийн шийдвэрийг ханган ажиллаж, 2025 оны хийгдэх ажлыг 95 хувиас дээш дүгнүүлсэн байна.</p>	<p>"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан. "Стратеги төлөвлөгөө-2050", мөн өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүний нөөцийн стратеги 2021-2030" бодлогын баримт бичгийн хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээ хийж удирдлагад танилцуулсан.</p>	100%

			сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухай бүр хангаж ажилласан.		"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд улирал бүр үнэлгээ хийж ЗТЯаманд хүргүүлж байна. Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын албаны батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналтын ажлыг гүйцэтгэж компанийн үндсэн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, дүгнэлт өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	
6.2	Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон Компанийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, ЗТЯ-нд хүргүүлэх.	Хэрэгжилтийн хувь	Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны хэрэгжилт III улирлын байдлаар 88.13 хувьтай байна.	I-IV улирал: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн үнэлгээ хийж үнэлгээг тухай бүр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн байна.	Компанийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээ хийж удирдлагад танилцуулан 2025 оны I, II, IV улиралд ЗТЯаманд хүргүүлсэн. Компанийн газар, нэгжийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр үнэлгээ хийж удирдлагад танилцуулан холбогдох хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100%

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Төлөвлөгөө тайлагнасан:
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Б.ДЭЛГЭРСАЙХАН/
2026 оны 03 сарын 16 өдөр

Төсвийн шууд захирагч

/Х.ПҮРЭВЖАРГАЛ /

2026 оны 02 сарын 10 өдөр